



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 5/17

Чингис хот

Гэрээт ажилчдыг шагнаж, урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.11, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн гэрээт ажилтнуудыг "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн дөрөвдүгээр үе шатны хүрээнд 2017 оны 1 дүгээр улирлын хийсэн ажлын үр дүнг үндэслэн мөнгөн шагналаар шагнаж урамшуулсугай.

2. Шагнал, урамшуулал авах Архивын тасгийн гэрээт ажилтнуудын нэрс шагнаж урамшуулах мөнгөн шагналын зардлын тооцоог хавсралтаар баталсугай.


3. Уг арга хэмжээний зардалд зарцуулах 213000 /хоёр зуун арван гурван мянган/ төгрөгийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансны гэрээт ажилчдын цалингийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Н. Шинэбаярт/ даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2017 оны 04 дугаар сарын 10-ны
өдрийн 5/17 дугаар тушаалын хавсралт



АРХИВЫН ТАСГИЙН ГЭРЭЭТ АЖИЛТНУУДЫН НЭРС,
ШАГНАЖ УРАМШУУЛАХ МӨНГӨН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Овог нэр	Шагнаж, урамшуулах мөнгөн дүн	10%-ийн шимтгэл	Нийт
1.	Ц.Мягмар-Ариунаа	106500	10650	95850
2.	Э.Хулан	106500	10650	95850
Дүн		213000	21300	191700